

БАТЛАВ



Б.БАТЖАРГАЛ, СУРГАЛТ ЭРХЭЛСЭН ПРОРЕКТОР

Сургалтын төлөвлөгөөний биелэлт тооцох удирдамж

Үндэслэл: Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн “Мэргэжлийн чиглэл (хөтөлбөрийн нэр), индекс батлах тухай” А/160 дугаар тушаал, 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “МУИС-ийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл”, 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн захиргааны зөвлөлийн хурлын шийдвэр, “МУИС-ийн ХЕХ-ны хорооны 2023 оны 06 дугаар сарын 08, 16, 11 дүгээр сарын 10-ны өдрийн хорооны хурлын шийдвэр

Зорилго: МУИС-ийн сургалтын хөтөлбөрийн журмын дагуу 2023 онд шинэчлэгдсэн хөтөлбөрүүдийн дагуу мэргэжлийн хөтөлбөр сонгосон, мэргэжлийн хөтөлбөр сонгох, МУИС-ийн хөтөлбөр хооронд шилжин суралцаж байгаа суралцагчид, судалгааны магистр, Шинжлэх ухаан технологийн Улаанбаатар паркийн бакалавр, магистр, докторын сургалтын төлөвлөгөөний биелэлт тооцоход удирдамж болгоно.

Үйл ажиллагаа:


- Хөтөлбөрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн “Чөлөөт сонголтын хичээл шилжүүлэх маягт”-ыг суралцагчаар бөглүүлэн хянаж, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэнд шилжүүлснээр тухайн хичээлийг “Чөлөөт сонголт” багцад хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн шилжүүлнэ.
- Судалгааны магистрын хөтөлбөрийн суралцагч өөрийн хөтөлбөрөөс илүү судалсан хичээлийг ижил түвшний бусад хөтөлбөрөөс багцад тооцуулах бол суралцагчийн хүсэлтийг үндэслэн хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн шилжүүлнэ.

Сургалтын төлөвлөгөөний биелэлт тооцох

- 2022-2023 оны хичээлийн жилийн хаврын улирлаас хойш шинэчлэгдсэн хөтөлбөрүүдийн дагуу мэргэжлийн хөтөлбөр сонгосон, МУИС-ийн хөтөлбөр хооронд шилжин суралцсан, “Ерөнхий суурь хичээл”-ийн багц цагаа гүйцээсэн боловч хөтөлбөрийн шаардлагаар ерөнхий суурийн хичээл нэмж судалсан тохиолдолд илүү судалсан хичээлийг “Чөлөөт сонголт” багцад тооцож болно. *Ерөнхий суурийн хөтөлбөрийн шаардлага хичээл судалснаас хойш судалсан ерөнхий суурийн хичээлийг “Чөлөөт сонголт” багцад тооцохгүй. Мөн бусад багцад ерөнхий суурийн хичээлийг шилжүүлж тооцохгүй.*
- Бакалаврын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлттэй холбоотойгоор зарим хөтөлбөрийн “Ерөнхий суурь хичээл”-ийн аль нэг бүлгийн багц цаг багассантай холбоотойгоор 2022-2023 оны хичээлийн жилд элссэн суралцагчид тухайн хичээлийн жилд “Ерөнхий суурь хичээл”-ийн багцаас илүү судалсан хичээлийг “Чөлөөт сонголт” багцад тооцож болно.
- Зүүн бүсийн сургууль, Баруун бүс сургуулийн хувьд бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор “Ерөнхий суурь хичээл” багцаас илүү судалсан ерөнхий суурийн хичээлийг “Чөлөөт сонголт” багцад тооцож болно.

Шинжлэх ухаан технологийн Улаанбаатар паркийн сургалтын төлөвлөгөөгөөр суралцагчдын хувьд:

- Бакалаврын хөтөлбөрийн III, IV түвшний суралцагчдыг одоогийн суралцаж байгаа сургалтын төлөвлөгөөний дагуу суралцуулж төгсгөнө.
I, II түвшний суралцагчдыг харгалзах бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрт тушаал гаргаж шилжүүлнэ.
- Ахисан түвшний хөтөлбөрийн суралцагчдыг элсэн суралцсан сургалтын төлөвлөгөөний дагуу суралцуулж төгсгөнө.
- Суралцагчийн хүсэлтээр харьяалал шилжиж ирсэн бүрэлдэхүүн сургуулийн харгалзах хөтөлбөрт шилжин суралцаж болно



2024 оны 03 дугаар сарын 14